TDB

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК



# Жилийн тайлан 2008

# АГУУЛГА


- Эрхэм зорилго, Хэтийн зорилго
- Санхүүгийн үзүүлэлтүүд

**Мэндчилгээ**

- Ерөнхийлөгчийн илгээлт
- Гүйцэтгэх захирлын илгээлт

**Банкны тухай**

- Банкны бүтэц
- Товч танилцуулга
- Оны онцлох үйл явдлууд
- Шагнал урамшуулал
- Захирлуудын зөвлөл

**Банкны үйл ажиллагаа**

- Байгууллагуудад зориулсан үйл ажиллагаа
- Жижиг, дунд байгууллагуудад зориулсан үйл ажиллагаа
- Иргэдэд зориулсан үйл ажиллагаа
- Олон улсын харилцаа, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа
- Хөрөнгө зохицуулалт, арилжааны үйл ажиллагаа

**Эрсдэлийн удирдлага**

**Мэдээллийн технологийн дэвшил**

**Хүний нөөцийн удирдлага**

**Нийгмийн хариуцлагын хүрээнд хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд**

**Аудитын тайлан**

**Хавсралт**

- Корреспондент банкуудын тухай товч мэдээлэл
- Салбар, тооцооны төвүүдийн хаяг, утас

ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК

## Эрхэм зорилго

Худалдаа Хөгжлийн Банк (ХХБ) нь Монгол улсын олон талт үйл ажиллагаатай, тэргүүлэх зэргийн банкны хувьд том, жижиг дунд, жижиг харилцагчдын зах зээлийн эрэлт хэрэгцээнд үндэслэсэн, үнэ цэнэтэй банкны үйлчилгээг хөгжүүлэн хүргэж, үйлчилгээнээс хүртэх сэтгэл ханамжийг байнга, хамгийн өндөр түвшинд байлгахад зорин ажиллана. Бид бүхний амжилт ололт шилдэг сайн үйлчилгээ, өндөр мэргэжлийн боловсон хүчин, хамтын удирдлагын дээд зэргийн арга барилд үндэслэх болно.

## Хэтийн зорилго

ХХБ нь Монгол улсын банк санхүүгийн зах зээлд тэргүүлэгч, олон улсын шилдэг туршлагуудыг үйл ажиллагаандаа бүрэн хэрэгжүүлсэн олон талын үйл ажиллагаатай банк, харилцагч үйлчлүүлэгч, хамтрагч түншүүдийнхээ санхүүгийн сайн сайхан, тогтвортой байдалд хүрэхэд тууштай, хариуцлагатай туслагч, итгэл найдварыг нь хүлээсэн түнш нь байсаар байх болно.

## Банкны үнэлгээ - Moody's үнэлгээний байгууллагын үнэлгээ (2009.02.15)

| | |
|---|---|
| > УХ*/БХ* Татан төвлөрүүлсэн хөрөнгө (Гадаад валютаар) | B2 |
| > УХ/БХ Татан төвлөрүүлсэн хөрөнгө (Дотоод валютаар) | Ba1 |
| > УХ/БХ Үнэлгээ авагч байгууллагын зэрэглэл (Гадаад валютаар) | Ba2 |
| > УХ/БХ Үнэлгээ авагч байгууллагын зэрэглэл (Дотоод валютаар) | Ba1 |
| > Барьцаагүй үнэт цаас (Гадаад валютаар) | Ba2 |
| > Хоёрдогч үнэт цаас (Гадаад валютаар) | Ba2 |
| > Хэтийн төлөв | Тогтвортой |

УХ* - Урт хугацаат
БХ* - Богино хугацаат

# 2006-2008 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОЙМ ҮЗҮҮЛЭЛТҮҮД

| Санхүүгийн үзүүлэлтүүд | 2007 | 2008 |
|---|---|---|
| | | *сая төгрөг* |
| **Орлого зарлагын хураангуй** | | |
| Хүүгийн орлого | 47,322 | 71,218 |
| Цэвэр хүүгийн орлого | 20,647 | 37,571 |
| Үйл ажиллагааны орлого | 31,073 | 37,596 |
| **Цэвэр ашиг** | **16,396** | **16,335** |

| Ашигт ажиллагааны үзүүлэлтүүд | 2007 | 2008 |
|---|---|---|
| Өөрийн хөрөнгийн өгөөж | 23.9% | 23.8% |
| Активын өгөөж | 2.9% | 2.5% |

| Хураангуй тэнцэл | 2007 | 2008 |
|---|---|---|
| **Актив хөрөнгө** | | |
| Мөнгөн хөрөнгө, банк болон санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгө | 110,375 | 140,812 |
| Зээл, үнэт цаас, урьдчилгаа | 382,308 | 440,259 |
| Бусад | 70,819 | 78,205 |
| **Нийт актив** | **563,503** | **659,275** |
| **Пассив хөрөнгө** | | |
| Харилцагчаас татан төвлөрүүлсэн хөрөнгө | 373,018 | 383,266 |
| Банк болон санхүүгийн байгууллагуудын хөрөнгө | 22,649 | 35,042 |
| Бусад пассив | 98,205 | 162,330 |
| Хоёрдогч өглөг | 9,359 | 10,140 |
| Нийт пассив | 503,233 | 590,778 |
| Өөрийн хөрөнгө | 60,270 | 68,497 |
| **Нийт пассив болон өөрийн хөрөнгө** | **563,503** | **659,275** |

| Зохистой харьцааны үзүүлэлтүүд | 2007 | 2008 |
|---|---|---|
| Өөрийн хөрөнгө, нийт цэвэршүүлсэн активын харьцаа (>10%) | 13.7% | 14.7% |
| Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцаа (<18%) | 26.0% | 37.0% |
| Гадаад валютын ханшийн эрсдэл (<10%) | 0.6% | 7.8% |
| Зээл төвлөрлийн эрсдлийн харьцаа (<20%) | 18.0% | 17.3% |
| Холбогдох этгээдийн зээлийн төвлөрлийн эрсдлийн харьцаа (<5%) | 0.1% | 0.1% |

Нийт орлогын өсөлт



Цэвэр ашгийн үзүүлэлт



Бизнесийн орлогын бүтэц



Зээлийн багцын өсөлт, чанарын динамик



# ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ИЛГЭЭЛТ



**Монгол улсын** эдийн засгийн **олон салбарт зо**гсонги байдал **бий болж, өсөл**т саарсан **боловч ХХБ зээ**лийн багцын **өсөлт, чанараа** эрсдэлийн **зөв удирдлагаа**р хангаж **ажилласан.** Мөн түүнчлэн, **зардлынхаа бүт**цийг зориулалт **тус бүрээр нь ня**гталж, хяналттай **удирдан, банк**ныхаа санхүүгийн **тогтвортой бай**длыг хангаж **ирсэн юм.**

**Рандолф Коппа**
(ХХБ-ны Ерөнхийлөгч,
МИК-ийн Гүйцэтгэх захирал)

## Эрхэмсэг ноёд, хатагтай нараа!

Өнгөрсөн 2008 онд Худалдаа, хөгжлийн банк их хичээл зүтгэлтэй ажиллаж, олсон олон амжилтын үр дүнгийн талаар Та бүхэнд энэхүү жилийн тайлангаар хүргэж байгаадаа баяртай байна.

Тайлант хугацаанд АНУ-д хавтгайруулан олгосон, эрсдэлтэй орон сууцны зээлийн хямрал санхүүгийн салбарт хүндээр туссан ба улмаар бусад олон улс оронд халдаж, хөгжиж буй болон аж үйлдвэржсэн орнуудын эдийн засгийн

өсөлтийг зогсонги байдалд оруулсан жил байлаа. Өнөөгийн даяаршсан цаг үед олон улсын санхүүгийн зах зээл дэх сөрөг нөлөө нь Монгол улсыг ч мөн тойрсонгүй. Монгол улсын эдийн засгийн олон салбаруудын өсөлт саарсан боловч ХХБ зээлийн багцын өсөлт, чанарын эрсдэлийг зөв удирдан, зардлынхаа бүтцийг зориулалт тус бүрээр нь нягтлаж, хяналттай удирдаж, ашиг орлогоо бататгахын зэрэгцээ банкныхаа тогтвортой байдлыг хангаж ажиллалаа. Өнгөрөгч оны эцэст чанаргүй зээлийн үзүүлэлт 1.6 хувьтай байсан нь ХХБ-ны сүүлийн жилүүдийн түүхэнд хамгийн бага болсон төдийгүй, Монголын банкуудын хамгийн доогуур үзүүлэлт байв. 2008 оны 12-р сарын байдлаар банкны төлбөр түргэн гүйцэтгэх чадвар 37% байгаа нь эдийн засгийн өсөлт бага, мөнгөний олдоц хязгаартай энэ үед ХХБ өөрийн бат бэх байр сууриа хэвээр хадгалахын төлөө тууштай ажилладагийн илрэл юм.

2008 оны туршид АНУ болон Ази, Европын улс орнуудын Засгийн газраас эдийн засаг, банк санхүүгийн салбараа идэвхижүүлэхээр дорвитой хөтөлбөрүүдийг боловсруулан хэрэгжүүлж байна. Монгол улсын төр засгаас банк санхүүгийн салбараа дэмжих, болзошгүй хямралаас урьдчилан сэргийлэх зорилгоор "Банкин дахь мөнгөн хадгаламжид баталгаа гаргах тухай", "Банкуудад Монгол улсыг хөгжүүлэх сангаас хөрөнгө байршуулах тухай" хуулиудыг УИХ-аар хэлэлцэн баталсан нь зоримог, нөлөө бүхий ач холбогдолтой алхам болсныг тэмдэглэн хэлэхэд таатай байна. Түүнчлэн, эдийн засгаа дэмжих зорилгоор Олон улсын валютын сан (ОУВС) болон бусад олон улсын хандивлагч байгууллагуудтай харилцан тохирч баталсан хөтөлбөрүүдийн хүрээнд төсвийн алдагдлыг багасгах, банкны салбарын төлбөрийн чадварыг дээшлүүлэн нэмэгдүүлэх арга хэмжээ авсан нь бидэнд эдийн засгийн цаашдын өсөлтийг тогтворжуулах, хурдасгах боломжийг бэхжүүлэх итгэлийг өглөө.

Өнгөрсөн саруудад Олон улсын үнэлгээний Moody's, S&P, Fitch байгууллагууд улс орон, арилжааны банкуудын үнэлгээг дахин хянаж бууруулаад байгаа ч Moody's үнэлгээний байгууллагаас 2007 онд ХХБ-ны гадаад валютын үнэт цаас гаргах чадварт тогтоосон Ba2 зэрэглэлийг 2008 оны 6, 12-р саруудад хийсэн үйл ажиллагааны шинжилгээ, дүгнэлтийг үндэслэн үргэлжлүүлэн хэвээр хадгалсан ба "тогтвортой сайн" үнэлгээг ХХБ-нд дахин өгсөн юм.

Монгол улсын эдийн засагт гадаадын хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэх, эдийн засгийг бодитойгоор дэмжих үүднээс ХХБ өнгөрөгч онд Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлаг (ГХОГХА)-тай хамтын ажиллагааны гэрээ байгуулж, Английн Лондон хотод болсон Монгол-Европын Хөрөнгө оруулагчдын чуулга уулзалт, Улаанбаатар хотноо зохион байгуулагдсан "Euromoney-2008" Хөрөнгө оруулагчдын чуулга уулзалт, Монгол-Японы бизнес форум зэрэг гадаад дотоодын арга хэмжээнүүдэд ерөнхий ивээн тэтгэгч, тэргүүлэгч хандивлагчаар тус тус оролцсон нь Монгол улсыг олон улсын санхүүгийн зах зээлтэй холбодог тэргүүний банк гэдгийг гадаадын улс орнуудад таниулсан хэрэг болсон юм.

Өөрөөр хэлбэл, гадаад төлбөр тооцооны 50 гаруй хувийг дангаараа гүйцэтгэж,

олон улсын 80 гаруй банк санхүүгийн байгууллагатай корреспондент харилцаатай ажилладаг манай банк нь олон улс дахь нэр хүндээ улам бүр нэмэгдүүлэх, олон улсын санхүүгийн зах зээлд эзлэх байр сууриа өргөжүүлэн бэхжүүлэх үйл ажиллагааны хүрээнд худалдааны санхүүжилтийн зээлийн шугам батлуулах, одоогийн хэрэглэгдэж буй зээлийн шугамуудын ашиглалтыг нэмэгдүүлэх зорилгодоо хүрч, уг харилцааны хүрээнд 2008 онд DZ банк, БНХАУ-ын Хөдөө аж ахуйн банкууд ХХБ-нд зээлийн шугам баталж өгснөөр худалдааны санхүүжилтийн зээлийн шугам оны эцсээр нийтдээ 113 сая ам.долларт хүрч, өмнөх оныхоос 12 хувиар нэмэгдсэн. Үүнээс гадна Шведийн кроноор төлбөр хийх боломжийг харилцагчиддаа олгосон нь тус банкаар дамжуулан төлбөр хийж болох 14 дэх гадаад валют болж байгаа юм.

Энэхүү захидлынхаа төгсгөлд бидний энэ зүтгэл, ажлын амжилтыг байнга дэмжиж, хамтран ажиллаж ирсэн нийт харилцагчид, хадгаламж эзэмшигчид, гадаад дотоодын түншүүддээ урт хугацааны дэмжлэг, хамтын ажиллагаанд нь талархсанаа илэрхийлэхийн зэрэгцээ гар нийлэн хамтран ажилласан ХХБ-ны нийт ажилтан, албан хаагчиддаа нөр их хөдөлмөр, хичээл зүтгэлд нь чин сэтгэлээсээ бахдан талархаж, ирж байгаа онд хамгийн шилдэг, гарамгай амжилт гаргахыг хүсэн ерөөж байна.



# ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ИЛГЭЭЛТ

Тайлант онд ХХБ-ны нийт актив 659.3 тэрбум төгрөгт хүрч, 17 хувиар өссөн бол өөрийн хөрөнгийн хэмжээ 68.5 тэрбум төгрөг болон өсч, татварын дараах ашиг 16.3 тэрбум төгрөгт хүрлээ.



**Балбарын Мэдрээ**
(Гүйцэтгэх захирал)

## ЭРХЭМ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД, ХАРИЛЦАГЧИД, БИЗНЕСИЙН ТҮНШҮҮД, АЖИЛТАН, АЛБАН ХААГЧИД АА!

Худалдаа, хөгжлийн банкны хувь нийлүүлэгчид, харилцагчид, хамтран ажилладаг байгууллага, аж ахуйн нэгжүүд, нийт түншүүд Та бүхэнд 2008 оны үйл ажиллагааны тайлан, гүйцэтгэлээ толилуулж байгаадаа нэн таатай байна.

Тайлант онд хэдийгээр дэлхий нийтэд санхүүгийн хямралын салхи давалгаалсан, хөгжингүй орнуудын эдийн засгийн хөгжил сулварсан, иргэдийн сэтгэл зүй тогтвортой бус, санхүүгийн зах зээл эрсдэл өндөртэй жил байсан ч Худалдаа, хөгжлийн банкны хувьд огтхон ч ажралгүй ололт амжилтаар арвин, чанар чансаагаа иттгэж чадсан онцгой жил болж өнгөрлөө.

Өнгөрөгч онд манай банк хүний хөгжлөөр ярьвал эрийн цээнд хүрч, 18 жилийн ойтойгоо золгосон тэмдэглүүштэй үйл явдал давхцаж, энэ өндөрлөгөөс харахад бидний хувьд дадлагажсан, урагшаа тэмүүлсэн, эрч хүч, амжилт ололтоор дүүрэн байсны зэрэгцээ санхүүгийн зах зээл дээр олон зүйлд анхдагч байж, харилцагч хамтран ажиллагчдынхаа эрэлт хэрэгцээг мэдрэн, чадварлаг боловсон хүчнээр хамт олноо бүрдүүлж чадсан он жилүүд байлаа.

Тайлант онд ХХБ-ны нийт актив 659.3 тэрбум төгрөгт хүрч, 17 хувиар өссөн бол өөрийн хөрөнгийн хэмжээ 68.5 тэрбум төгрөг болон өсч, татварын дараах ашиг 16.3 тэрбум төгрөгт хүрсэн нь манай банкинд хийсэн KPMG компанийн аудитад хамрагдан баталгаажсан билээ.

Бид тайлант онд дэвшүүлсэн зорилтот ажлуудаа амжилттай хэрэгжүүлж, хурдацтай хөгжиж буй санхүүгийн зах зээлд өөрийн тэргүүлэгч байр сууриа хэвээр хадгалан, дэвшилтэт шинэ бүтээгдэхүүн үйлчилгээнүүдийг нэвтрүүлэн, цар хүрээгээ өргөжүүлэн ажиллалаа. Картын хамгийн өргөн сүлжээ бүхий манай банк бэлэн бус төлбөр тооцооны соёлтой хэрэглээг байнга дэмжиж, хөгжүүлсээр ирсэн бөгөөд өнгөрөгч онд төлбөрийн картыг төлбөрт хүлээн авах сүлжээг өргөтгөх зорилгоор картаар үйлчлэгч үйлчилгээний байгууллагын тоог 31 хувиар, мөн карт хүлээн авах терминалын тоог 42 хувь хүртэл өсгөснөөр ХХБ-ны карт эзэмшигчдийн тоо 32 хувиар нэмэгджээ.

Цаг хугацаатай уралдан харилцагчдын эрэлт, хэрэгцээ өсөн нэмэгдэж байгаа өнөө үед бид бүтээгдэхүүн үйлчилгээгээ улам чанаржуулах, дэлхийн жишигт хүргэх шаардлага нэмэгдсээр байна. ХХБ 2008 онд олон улсын эрхтэй евро, ам.долларын сонголт бүхий Classic, Gold, Business, Platinum гэсэн 4 төрлийн MasterCard-ыг картын зах зээлд анх удаа нэвтрүүллээ.

Өнгөрөгч 18 жилийн хугацаанд бидэнтэй хамт байж, итгэл хүлээлгэн хамтран ажилласан дотоод гадаадын байгууллагууд, түншүүд, нийт харилцагчид бид бүхний тогтоосон хамтын ажиллагаа үгтан ирэх он жилүүдийн туршид ч үргэлжилсээр байх болно гэдэгт бид итгэлтэй байна.

ХХБ-ны удирдлагын баг, нийт захирлууд, ажилтнуудdaa шаргуу хөдөлмөрсөнд нь талархал илэрхийлье.




ТУЗ
Актив пассивын хороо
Удирдлагын хороо
Дотоод аудитын газар
Зээлийн хороо
Байгууллагын банкны газар
Маркетинг, бүтээгдэхүүн хөгжлийн газар
Хүний нөөцийн газар
Хуулийн хэлтэс
Салбарууд

# БАНКНЫ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

2008 оны 12-р сарын 31-ний байдлаар нийт актив 659.3 тэрбум төгрөг



Нийт зээл (зах зээлд эзлэх хувиар)



Нийт зээл эдийн засгийн салбарт



Пассив болон өөрийн хөрөнгө



ХХБ нь орчин үеийн тэргүүний технологид суурилсан банкны тогтолцоог бий болгож, үйлчилгээний цар хүрээ төрлийг ямагт өргөтгөн харилцагчидынхаа ашиг сонирхлыг дээдэлсэн нээлттэй ил тод бодлогыг тууштай хэрэгжүүлж ирлээ.

Арилжааны ууган банк болох ХХБ улс орны эдийн засгийн хөгжилд дорвитой хувь нэмэр оруулдаг банк санхүүгийн салбартаа гол ноён нуруутай, гол байр суурьтай тэргүүлэгч банк мөн билээ.

ХХБ томоохон аж ахуйн нэгж, байгууллагууд, жижиг, дунд бизнес эрхлэгчид болон олон мянган харилцагч иргэддээ зориулан урт ба дунд болон богино хугацааны санхүүжилт, худалдаа үйлчилгээг дэмжих олон төрлийн зээлийн бүтээгдэхүүн харилцагчийн хэрэгцээнд суурилсан хувийн банкны болон хөрөнгө зохицуулалтын үйлчилгээ, валютын арилжаа зэрэг олон улсын стандарт бүхий сүүлийн үеийн 60 гаруй нэр төрлийн бүтээгдэхүүнээр үйлчилж байна. Банкны бүтээгдэхүүн үйлчилгээг харилцагчиддаа 600 гаруй ажиллагсад, 26 салбар, тооцооны төв, 50 АТМ-аар харилцагчиддаа шуурхай хүрч ажиллаа.

ХХБ нь олон улсын хөрөнгийн зах зээлд зах зээлд байгууллагын анхны бондыг гаргаснаар Монголын хөрөнгийн зах зээлийн түүхэнд бичигдсэн, олон улсад нэрээ таниулсан томоохон алхам болсон. Гадаад харилцаа холбоогоо өндөр түвшинд хүргэн ажилласнаар өнөөдөр дэлхийн 80 гаруй банк санхүүгийн байгууллагатай корреспондент харилцаа тогтоон, гадаад төлбөр тооцооны 50 гаруй хувийг дангаараа гүйцэтгэж байна. Түүнчлэн, олон улсын түвшинд хэвшсэн дэвшилтэт бүтээгдэхүүн үйлчилгээнүүдийг нэвтрүүлэн, Монгол улсын тэргүүлэх томоохон 340 гаруй байгууллагуудад санхүүгийн зөвлөгөө өгч, төслийн болон хөрөнгийн санхүүжилт олгох, олон улсын хөрөнгийн зах зээлээс санхүүжилт авахад дэмжлэг үзүүлэн, томоохон санхүүгийн байгууллагуудын хамтын санхүүжилтийн үйл ажиллагаанд идэвхитэй оролцож байна.

## 2008 оны онцлох үйл явдлууд

- Олон улсын жишигт нийцсэн орчин үеийн өндөр нууцлал бүхий "Хадгаламжийн сертификат"-ийн бүтээгдэхүүнийг төгрөг, ам.долларын сонголттойгоор зах зээлд нэвтрүүллээ.
- Монгол улсын картын зах зээлд анх удаа "Евро", "Ам.доллар"-ын сонголт бүхий Classic, Gold, Business, Platinum гэсэн 4 төрлийн MasterCard-ыг гаргалаа.
- БНХАУ-ын Бээжин хотноо зохиогдсон зуны XXIX Олимпийн наадамд зориулан Visa International байгууллагатай хамтран 2 төрлийн "Олимп" Visa картыг зах зээлд амжилттай нэвтрүүллээ.
- Монголд анх удаа нэвтрүүлсэн Цахим нэхэмжлэх буюу И-биллинг үйлчилгээгээ өргөтгөж үүрэн телефон холбооны оператор Скайтел, Юнител, Жи-Мобайл корпорациудтай хамтарлаа.
- Дотоодын зах зээлд Шведийн крон (SEK)-ын гүйлгээ, гуйвуулга, төлбөр тооцоог гүйцэтгэх боломжийг нээсэн анхны банк болж, хамгийн олон гадаад валютаар харилцагчиддаа үйлчилдэгээ дахин баталлаа.
- Германы DZ банк, Agricultural Bank of China банкууд ХХБ-нд зээлийн шугам нээж өглөө.
- BNP Paribas, UBS, Dresdner банкуудтай шинээр болон өмнөх хамтын ажиллагаагаа улам өргөжүүлэн хамтран ажиллалаа.
- Монголын арилжааны банкуудаас "Биет алтны своп" арилжааг гадаадын томоохон банкуудын нэг болох "Goldman Sachs international" байгууллагатай хамтран амжилттай хэрэгжүүллээ.
- Дэлхийн банкны "Хувийн хэвшлийг хөгжүүлэх төсөл-2"-ын хүрээнд ХХБ-ны "Сургалтын хөтөлбөр-2008"-ыг боловсруулан Дэлхийн банкаар батлуулав.
- Монгол улсын эдийн засагт дорвитой хувь нэмэр оруулдаг томоохон харилцагч байгууллагуудынхаа зээлийн хэрэгцээнд зориулан Австрийн VTB банктай хамтран Хамтын санхүүжилтийн зээл олголоо.
- Дэлхий нийтийн хэрэглэгчдийг хил хязгааргүй нэгтгэж байгаа интернэт худалдаа эрхлэх боломжийг харилцагчдад олгох аюулгүй байдлыг бүрэн хангасан "Verified by Visa" технологийг өргөжүүлж, MasterCard-ын Secure Code технологийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг бүрэн хангалаа.
- Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлаг (ГХОГХА)-тай хамтын ажиллагааны гэрээ байгуулж, Монголын эдийн засагт гадаадын хөрөнгө оруулалтын ашиг тусыг нэмэгдүүлэх, эдийн засгийг бодитойгоор дэмжих чиглэлээр хамтран ажиллаж, гадаад дотоодын арга хэмжээ, олон улсын чуулга уулзалт зэрэг арга хэмжээнүүдийг хамтран зохион байгуулахад ХХБ ерөнхий ивээн



тэтгэгч, тэргүүлэгч хандивлагчаар ажиллалаа.

- Азийн банкны холбоонд ХХБ гишүүнээр элсэж, Гүйцэтгэх захирал Б.Мэдрээ тус холбооны Захирлын зөвлөлийн гишүүнээр сонгогдлоо.

## Шагнал урамшуулал

- Монголын Маркетинг, Менежментийн хүрээлэн Монгол улсын бизнесийн салбар бүрт шилдэгийг шалгаруулах олон нийтийн санал асуулгаар Худалдаа, хөгжлийн банк нь Банк, санхүү, даатгалын салбарын шилдгийн шилдэгээр тодорч "Гран При" шагналыг хүртлээ.
- Олон улсын MoneyGram байгууллагаас Худалдаа, хөгжлийн банкийг 2008 оны "Маркетингийн шилдэг хамтрагч байгууллага"-аар шалгаруулжээ.
- ХХБ-ны Гүйцэтгэх захирлын тэргүүн орлогч О.Орхон "Монголын бахархалт залуу"-гаар тодорлоо.
- Монголбанкны "Банк, санхүүгийн тэргүүний ажилтан" цол тэмдгээр Д.Гантөгс, Д.Нямрэнцэн, "Хүндэт жуухаар" Д.Сарантуяа, Ч.Бямбасүрэн, С.Долгоржав нар шагнуулаа.
- Монголын банкны холбооны 2008 оны банкны салбарын "Шилдэг нягтлан бодогч-теллер"-ээр Н.Цэцгээ, М.Долгор, "Шилдэг зээлийн эдийн засагч"-аар Б.Баяржаргал нар шалгарлаа.
- Монголын банкируудын холбооны 2008 оны "Шилдэг банкир"-аар А.Мөнхбаясгалан тодорлоо.
- Нийслэлийн Засаг даргын тамгын газрын нэрэмжит шагналаар Т.Эрдэнэчимэг, Г.Онон нар шагнуулаа.
- МЗХ-ны "Тэргүүний залуу" медалийг Ц.Отгонбилэг, Ц.Цэнгэл, С.Наран, "Хөдөлмөрийн алдар" медалийг С.Нарангоо, Ч.Пүрэвжаргал нар гардан авлаа.
- 2008 оны Банк хоорондын сагсан бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээнээс Д.Бат-Эрдэнэ ахлагчтай баг тамирчид "Алтан медаль", Банк хоорондын ширээний теннисний аварга шалгаруулах тэмцээнээс багийн дүнгээр "Алтан медаль", Банк хоорондын Волейболын АШТ-ий "Шилдэг холбон тоглогч"-оор Г.Сүхчулуун, Хөлбөмбөгийн аварга шалгаруулах "Boroo cup-2008" тэмцээний "Алтан медаль", Б.Ганболд "Шилдэг тоглогч"-оор шалгарсан спортын арвин амжилттай байлаа.

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

Дарга

Д.Эрдэнэбилэг

Гишүүд:

Д.Мөнхбаатар
Ч.Энхболд
Т.Болдхүү
Т.Цолмон

## УДИРДЛАГЫН ХОРОО

**Рандолф Коппа**
Ерөнхийлөгч

**Б.Мэдрээ**
Гүйцэтгэх захирал

**О.Орхон**
Гүйцэтгэх захирлын тэргүүн орлогч

**Д.Гантөгс**
Гүйцэтгэх захирлын орлогч

**Д.Хүрэлбаатар**
Гүйцэтгэх захирлын орлогч

**Ононгийн ОРХОН**
Гүйцэтгэх захирлын тэргүүн орлогч





**Дамдины ГАНТӨГС**
Гүйцэтгэх захирлын орлогч

**Дамбийжавын ХҮРЭЛБААТАР**
Гүйцэтгэх захирлын орлогч



# Удирдлагын баг

**Ичинноровын**
**ОРХОНХҮҮ**
Мэдээллийн технологийн газрын захирал

**Найдансүрэнгийн**
**ЗОЛЖАРГАЛ**
Гадаад харилцаа, хөрөнгө оруулалтын банкны газрын захирал

**Баярбаатарын**
**БАЯРМАА**
Иргэдийн банкны газрын захирал

**Дэмчигжавын**
**ОТГОНБИЛЭГ**
Эрсдэлийн удирдлагын газрын захирал

**Паламдоржийн**
**ГАНТУУЛ**
Дотоод аудитын газрын захирал

**Ванчигсүрэнгийн**
**ЭНХЦЭЦЭГ**
Салбар банкны хэлтсийн захирал

**Ширэндэвийн**
**ЭРДЭНЭБААТАР**
Хамгаалалт, аюулгүй байдлын газрын захирал

**Аниагийн**
**МӨНХБАЯСГАЛАН**
Маркетинг, бүтээгдэхүүн хөгжлийн газрын захирал

**Шаравсамбуугийн**
**ЭНХТӨР**
Хуулийн хэлтсийн захирал

**Дагмидын**
**ЯНЖМАА**
Санхүүгийн бүртгэл, хяналтын газрын захирал

**Лувсангийн**
**НЯМСҮРЭН**
Хүний нөөцийн газрын захирал

**Навааншаравын**
**НЯМСҮРЭН**
Байгууллагын банкны газрын захирал

**Гомбосүрэнгийн**
**ӨСӨХБАЯР**
Жижиг, дунд байгууллагын банкны газрын захирал



# TDB

## ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНК

# НАЙДВАРТАЙ, ЭРСДЭЛГҮЙ

## ҮЗҮҮЛЭЛТЭЭРЭЭ ИТГЭЛ ХҮЛЭЭСЭН, ГАДААД ХУДАЛДААНЫ САНХҮҮЖИЛТИЙН ХАМГИЙН ӨРГӨН ГАРЦТАЙ БАНК

ОЛОН УЛСЫН 26 БАНК, САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГААС НИЙТДЭЭ 113 САЯ ОРЧИМ
АМ.ДОЛЛАРЫН ХУДАЛДААНЫ САНХҮҮЖИЛТИЙН [illegible]
[illegible] ГАДААД ХУДАЛДААНЫ АККРЕДИТИВ БОЛОН БАТЛАН ДААЛГЫГ
БАТАЛГААЖУУЛЖ БУЙ МОНГОЛЫН ХАМГИЙН ӨРГӨН
ГАДААД ХАРИЛЦААТАЙ БАНК

### ЕВРОП

ING Bank, Brussels
Trade Finance Line

Commerzbank, Frankfurt-Main
Trade Finance Line

UniCredit Bank, Moscow
Trade Finance Line

Vneshtorgbank, Moscow
Trade Finance Line

Gazprombank, Moscow
Trade Finance Line

Bank Austria Creditanstalt Vienna
Trade Finance Line

BHF-Bank, Frankfurt-Main
Trade Finance Line

RZB, Vienna
Trade Finance Line

Atlantic Forfaitierungs, Zurich
Trade Finance Line

DZ Bank
Trade Finance Line

### АМЕРИК

International Finance Corporation, Washington
Global Trade Facilitation Program

American Express Bank, New York
Trade Finance Line

SMBC, New York
Trade Finance Line

### АЗИ

Korea Development Bank, Seoul
Trade Finance Line

The Export – Import Bank of Korea, Seoul
Comprehensive credit facility
for the support of Korean Export

Shenzhen, Beijing
Trade Finance Line

Bank Turan-Alem, Almaty
Trade Finance Line

Industrial & Commercial Bank of China, Erlian
Trade Finance Line

Taiwan EXIM Bank, Taiwan
Relending facility to support
Taiwanese Exports

Bank Center Credit, Almaty
Trade Finance Line

Agricultural Bank of China, Hohhot
Trade Finance Line

Alliance Bank, Almaty
Trade Finance Line

China Construction Bank Beijing
Trade Finance Line

Kazkommertsbank, Almaty
Trade Finance Line

Mizuho Corporate Bank, Tokyo
Trade Finance Line

Halyk Insurance Corporation, Almaty
Trade Finance Line

Утас: (976 11) 312362, 331133 Факс: (976) 11 327028, 331155 www.tdbm.mn

# Байгууллагуудад зориулсан үйл ажиллагаа



**ХХБ эдийн засгийн хөгжилд дорвитой хувь нэмэр оруулагч томоохон харилцагч байгууллагууддаа банкны бүх төрлийн үйлчилгээг цогцоор нь чанартай хүргэх, нэг харилцагчаас олох орлогыг нэмэгдүүлэх, чанартай зээлийн багц бүрдүүлэх, зээлийн багцад эзлэх чанаргүй зээлийн хэмжээг бууруулах зорилтуудыг тавьж ажиллаа.**

ХХБ эдийн засгийн хөгжилд дорвитой хувь нэмэр оруулагч томоохон харилцагч байгууллагууддаа банкны бүх төрлийн үйлчилгээг цогцоор нь чанартай хүргэх, нэг харилцагчаас олох орлогыг нэмэгдүүлэх, чанартай зээлийн багц бүрдүүлэх, зээлийн багцад эзлэх чанаргүй зээлийн хэмжээг бууруулах зорилтуудыг тавин ажилласнаар зээлийн багцын хэмжээ өмнөх оноос 19 хувиар, хүү шимтгэлийн орлого 68 хувиар

тус тус өссөн бөгөөд энэ нь Монгол улсын эдийн засгийн голлох салбаруудад бүтээгдэхүүн үйлчилгээгээ хүргэж ажиллаж байгаагийн нэгэн илрэл юм.

Тайлант оны сүүлийн хагас жилд олон улсын санхүү, эдийн засагт үүссэн хүндрэлтэй нөхцөл байдлаас шалтгаалан шинэ зээл олголтод тодорхой хязгаар тавин, зээлийн эргэн төлөлт болон багцын чанарт илүү анхаарал тавьж ажилласан бөгөөд зээлийн багцын дүн оны эхэнд төлөвлөсний дагуу өмнөх онтой харьцуулахад 53.59 тэрбум төгрөгөөр өссөн ба тайлант оны эцэст зээлийн багц 331.08 тэрбум төгрөгт хүрсэн байна.

Монгол улсын эдийн засгийн хөдөлгөгч хүч болсон байгууллагын зээлийн багцын эхний хагас жилийн эрчимтэй өсөлт болон худалдааны санхүүжилтийг нэмэгдүүлэх бодлогын хүрээнд 2008 оны зээлийн хүү, аккредитив, баталгааны шимтгэлийн орлогын төлөвлөгөөг 36.28 хувиар давуулан биелүүлж, нийт 44.74 тэрбум төгрөгт хүрлээ.







## Төслийн санхүүжилт

ХХБ Монгол улсын тэргүүлэх томоохон 340 гаруй байгууллагуудад санхүүгийн зөвлөгөө өгөх, төслийн болон хөрөнгийн санхүүжилтийн дэмжлэг үзүүлсээр ирсэн бөгөөд тайлант 2008 онд газар тариалан, хүнсний ногоо, мал аж ахуй, хүнсний үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих үүднээс Засгийн газраас хэрэгжүүлж буй хүүгийн хөнгөлөлттэй, урт хугацаат төслүүдийг амжилттай санхүүжүүлэн ажиллаж, 2008 оны жилийн эцсийн байдлаар нийт 5.05 тэрбум төгрөгийн төслийн зээл олгожээ.




Түүнчлэн, гадаадын томоохон банк санхүүгийн байгууллагууд болон дотоодын банкуудтай хамтран өөрийн олгох зээлийн дээд хязгаараас давсан төслүүдийг санхүүжүүлэн ажиллалаа. Тухайлбал, Дэлхийн банк, Германы KfW, Солонгосын Exim банкны эх үүсвэртэй дунд болон



Аккредитив, баталгааны шимтгэлийн орлогын өсөлт



урт хугацаат эргэлтийн болон хөрөнгө оруулалтын зээлийн хөтөлбөр, Хүнс, хөдөө аж ахуйн яамны хүүгийн хөнгөлөлттэй урт хугацаат зээлийн хөтөлбөр болон ноолуурын үйлдвэрлэгч нарт олгосон дунд хугацааны зээлийн хөтөлбөр зэрэгт өөрийн үндсэн зээлдэгч нарыг хамруулан, бизнесийн үйл ажиллагааг нь өргөжүүлэн хөгжүүлэх, гадаад зах зээлд хүрээгээ тэлэхэд нь дэмжлэг үзүүллээ.

## Худалдааны санхүүжилт

Тайлант онд зээлийн багцын чанарыг сайжруулж, эрсдэлийг бууруулах үүднээс Монгол улсын эдийн засгийн тэргүүлэх салбарууд болох уул уурхай, нефть бүтээгдэхүүн, ноос ноолуур болон худалдааны салбарт баримтлах бодлого, журам, аккредитив, баталгааны журмыг өнөөгийн зах зээлийн хөгжил дэвшил, нөхцөл байдалтай уялдуулан шинэчлэн боловсруулсан нь харилцагчдын эрэлт хэрэгцээг мэдэрсэн, бүтээгдэхүүн үйлчилгээ авах нөхцлийг нь сайжруулсан чухал алхам боллоо.

ХХБ нь худалдааны санхүүжилтийн үндсэн хэрэгслүүд болох дараах бүтээгдэхүүн үйлчилгээг харилцагчиддаа үзүүлж ирлээ. Үүнд:

- Бүх төрлийн аккредитив
- Бүх төрлийн баталгаа
- Гадаад худалдааны инкасс
- Японы буцалтгүй тусламжийн төлбөр тооцоо

Аккредитив, баталгаа, инкассын үйл ажиллагааг Монголбанк болон ХХБ-наас батласан заавар журмууд, олон улсын нийтлэг журам, стандартад тулгуурлан түргэн шуурхай, мэргэжлийн өндөр хэмжээнд гүйцэтгэн ирсэн туршлагатай бөгөөд тайлант онд нийт 489 аккредитив, баталгаа, инкасс, Японы буцалтгүй тусламжийн төлбөр тооцоог хийж гүйцэтгэлээ.

ХХБ томоохон аж ахуйн нэгжүүд, бизнес эрхлэгчдийн бизнес төлөвлөлтийн санхүүгийн үндсэн хэсэг болох мөнгөн урсгалын таамаглалыг хэрхэн тооцох загварыг бизнесийн онцлог шинжээс нь хамааран салбар тус бүр дээр боловсруулсан нь банкны харилцагчдад ирээдүйн бэлэн мөнгөний урсгалаа зөв тооцоолж, үр дүнтэй, өндөр ашигтай ажиллахад нь ихээхэн хувь нэмэр орууллаа.

ХХБ Монгол улсын эдийн засгийн өсөлтөд чухал үүрэг

гүйцэтгэдэг жижиг, дунд бизнес эрхлэгчдэд зориулан бизнесийн үйл ажиллагааны онцлогт нь тохирсон, тааламжтай нөхцөл бүрдүүлсэн зээл олгох, санхүүгийн зөвлөгөө өгөх, болзошгүй эрсдэлээс хамгаалах, улмаар зээлийн багцын чанарыг сайжруулж, ашигт ажиллагааг нэмэгдүүлэх зорилго тавин ажилладаг юм.

# Жижиг, дунд байгууллагуудад зориулсан үйл ажиллагаа

Жижиг, дунд байгууллагын банкны газрын орлогын өсөлт




Тайлант онд жижиг, дунд байгууллагуудад банкны цогц үйлчилгээг хялбар, түргэн шуурхай хүргэх үүднээс Жижиг, дунд байгууллагын банкны газар (ЖДББГ)-ын дотоод бүтэц, зохион байгуулалтыг өөрчилж, 2008 оны 3 дугаар сараас эхлэн дамжлагын тогтолцоогоор үйл ажиллагаа явуулан, зээлийн шинжилгээ болон зээлийн хяналтын хэсгүүдэд хуваан өөрчилснөөр зээлийн шинжилгээний явц илүү шуурхай, төрөлжсөн байдлаар хийгдэж, зээлийн эргэн хяналт нарийсч, ажлын бүтээмж нэмэгдлээ.

Тайлант онд ХХБ нь жижиг, дунд бизнес эрхлэгчдэд зориулан нийт 23.85 тэрбум төгрөгийн зээл олгож, оны эцсээр зээлийн үлдэгдэл 20.32 тэрбум төгрөгт хүрсэн нь өнгөрсөн оны эцэстэй харьцуулахад 24,5 хувиар өссөн байна.

Жижиг, дунд байгууллагын олгосон зээлийн өсөлт



Ийнхүү эдийн засгийн хөгжилд томоохон хувь нэмэр оруулдаг жижиг, дунд байгууллагуудад олгосон зээлийн багц өссөнөөр энэ төрлийн зээлийн нийт орлого 4.0 тэрбум төгрөгт хүрч, 1.58 тэрбум төгрөгийн ашигтай ажиллалаа.

ЖДБ-ын зээлийн багцын бүтэц (эдийн засгийн салбараар)



ХХБ нь жижиг, дунд бизнес эрхлэгчдийг санхүүгийн үйлчилгээгээр дэмжээд зогсохгүй үйл ажиллагааг нь өргөжүүлэн хөгжүүлэхийг зорьж ажилладаг бөгөөд тайлант онд Дэлхийн банк болон Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны банкуудтай харилцаагаа үргэлжлүүлэн хамтран ажиллаж, жижиг, дунд бизнес эрхлэгчдийг 10 хүртэл жилийн хугацаатай, дотоодын банк санхүүгийн зах зээлээс бага хүүтэй, төслийн зээлээр санхүүжүүлэн, бизнесийн үйл ажиллагааг нь дэмжлээ. Түүнчлэн, харилцагчдын Тайвань болон Өмнөд Солонгос улсуудтай хийх худалдааны эргэлтийг дэмжиж, 3 хүртэл жилийн хугацаатай, хямд өртөгтэй эх үүсвэрээр санхүүжүүлэн ажиллалаа.



# Иргэдэд зориулсан үйл ажиллагаа

Тайлант онд ХХБ иргэдэд зориулсан бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ цар хүрээг улам өргөжүүлэх, цаг тутам өсөн нэмэгдэж буй харилцагчдын хэрэгцээ, шаардлагад нийцсэн техник, технологийн дэвшилтэт арга хэрэгсэл бүхий хамгийн уян хатан нөхцөлтэй шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх зорилгоо амжилттай биелүүлэн ажиллалаа.

Шинээр бүтээгдэхүүн үйлчилгээг амжилттай нэвтрүүлэхийн зэрэгцээ уламжлалт бүтээгдэхүүн үйлчилгээний хүү шимтгэлийг харилцагчдад илүү таатай, нийцтэй байдлаар өөрчлөлт оруулсан нь харилцагчдын сэтгэл ханамжийг дээшлүүлж, шинэ харилцагчдын тоог нэмэгдүүлэхэд ихээхэн түлхэц боллоо.

Иргэдийн банкны газрын харилцагчдын өсөлт




Иргэдэд олгосон зээлийн өсөлт




Иргэдэд олгосон зээлийн бүтэц (зээлийн төрлөөр)



## Зээлийн үйлчилгээ

ХХБ иргэдийн санхүүгийн хэрэгцээг хангах зээлийн олон төрлийн үйлчилгээг хүү, шимтгэлийн өрсөлдөхүйц нөхцөл, уян хатан бодлоготойгоор үзүүлдэг бөгөөд 2008 оны эцэст зээлийн өрийн үлдэгдэл 89.4 тэрбум төгрөгт хүрч, банкны нийт зээлийн багцын 20 хувийг эзэлж байгаа нь өмнөх оны эцсээс 42 хувиар өссөн юм.

Зээлийн төрлөөр авч үзвэл орон сууцны зээл 66.3 хувиар, хадгаламж барьцаалсан зээл 84.4 хувиар, цалингийн зээл 183.1 хувиар тус тус өссөн нь нийт зээлийн багцын өсөлтөд томоохон хувь нэмэр оруулжээ.
2004-2008 онуудын зээлийн багцын дүнг харьцуулан үзүүлвэл:

Ийнхүү, зээлийн багцын хэмжээ өссөнөөр нийт хүүгийн орлого 36.7 %-иар өсч, 14.4 тэрбум төгрөгт хүрсэн ба тайлант онд жижиг бизнесийн зээл, хэрэглээний зээл, тэтгэвэр барьцаалсан зээлүүдийн нөхцлийг харилцагчдад тааламжтайгаар хөнгөлөн өөрчилсөн нь зээл олголтыг нэмэгдүүлсэн бол Орон сууцны зээлийг хуваарьт төлбөрөөс илүү дүнгээр төлөхөд авах шимтгэлийг тэглэсэн нь харилцагчдын хүсэл сонирхолд нийцсэн алхам болсон

төдийгүй зээлийн нөхцлийг уян хатан байлгах бодлогын нэгэн илрэл юм.

Тайлант онд ХХБ нь "Монголын ипотекийн корпораци" ХХК-тай хамтын ажиллагаагаа өргөжүүлэн, ипотекийн зээлийн багцыг шилжүүлснээр харилцагчдад урт хугацаат орон сууцны зээлийг олгох шинэ эх үүсвэрийг бий болголоо. Түүнчлэн, байнгын хамтран ажилладаг харилцагч байгууллагууддаа итгэл хүлээлгэн, ажилтнуудыг нь хөнгөлөлттэй нөхцөл бүхий орон сууцны зээлд хамруулаа.




## Хадгаламжийн үйлчилгээ

Тайлант онд иргэдээс татан төвлөрүүлсэн хадгаламжийн хэмжээ 165.1 тэрбум төгрөгт хүрсэн ба үүнээс хугацаагүй хадгаламжийн үлдэгдэл 50.2 тэрбум төгрөг, хугацаатай хадгаламжийн үлдэгдэл 114.9 тэрбум төгрөг болж нэмэгдсэн нь иргэдийн нийт хадгаламж өмнөх оны мөн үеийнхтэй харьцуулахад 5.45 хувиар өссөн үзүүлэлттэй байна.




Харилцагчдын эрэлт хэрэгцээг хангасан шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэх зорилгын хүрээнд тайлант онд санхүүгийн зах зээл дээр чөлөөтэй хөрвөх чадвартай, дэлхийн жишигт нийцсэн Хадгаламжийн сертификатийн бүтээгдэхүүнийг төгрөг, ам.долларын гэсэн үндсэн хоёр валютын төрлөөр зах зээлд нэвтрүүлж ажилласан нь цаг үеэ олсон оновчтой алхам боллоо. Мөн 9 сарын хугацаатай хадгаламжийн бүтээгдэхүүнийг төгрөг, ам.доллар, юань гэсэн валютын төрлөөр зах зээлд нэвтрүүлж, ажил олгогч, ажилтан хоорондын уялдаа холбоог бататгасан "Ажил олгогчийн урамшуулалт хадгаламж"-ийн бүтээгдэхүүнийг харилцагчдад хүргэлээ.

## Картын үйлчилгээ

Монголын банк санхүүгийн байгууллагуудаас анх удаа картын хамгийн өргөн хүрээ, цоо шинэ, дэвшилтэт олон төрлийн төлбөрийн картуудыг зах зээлд нэвтрүүлсэн банк бол Худалдаа, хөгжлийн банк юм.

Тайлант онд картын бүтээгдэхүүн үйлчилгээнүүдийг сайжруулах, боловсронгуй болгох, шинэ төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээг нэвтрүүлэх, картаар үйлчлэгч байгууллагуудын сүлжээг нэмэгдүүлэх зорилтуудаа амжилттай гүйцэтгэн ажиллалаа.



Картын үйлчилгээний орлого




Картаар үйлчлэгч байгууллагын өсөлт




Гадаадын банкуудтай хийсэн төлбөр тооцооны өсөлт




Картын өргөн хүрээ, харилцагчдын тоогоор тэргүүлэгч байр сууриа бататган, 2008 онд олон улсын эрхтэй Classic, Gold, Business, Platinum гэсэн 4 төрлийн MasterCard-ыг "Евро", "Ам.доллар"-ын сонголттойгоор Монголын зах зээлд нэвтрүүлсэн нь анхдагч болж чадсан юм. Түүнчлэн, Зуны Олимпийн 29-р наадамд зориулан Visa International байгууллагатай хамтран 2 төрлийн "Олимп" Visa картыг харилцагчиддаа хүргэлээ.

Харилцагч, карт эзэмшигчдийнхээ эрэлт хэрэгцээг судалж, түүнд нийцсэн бүтээгдэхүүн үйлчилгээг санал болгох зорилгоор 2008 онд картын бүтээгдэхүүн, үйлчилгээний хүү шимтгэл, хураамжийн нөхцлийг Монголын картын зах зээлийн хамгийн таатай доод хэмжээнд шинэчлэн тогтоосон юм. Тайлант оны эцсийн байдлаар зах зээлд гаргасан нийт картын тоо хэмжээ 34,000-д хүрч, 2007 онд зах зээлд гаргасан картын тоо хэмжээнээс даруй 22 хувиар өссөн бөгөөд 2008 онд карт эзэмшигчдийн тоо 137,000-д хүрсэн байна.

Тайлант онд дэлхийн төлбөрийн картын зах зээлд тэргүүлэгч VISA, MasterCard, AmericanExpress, JCB байгууллагуудтай харилцаа холбоогоо өргөжүүлэн тэлж, урамшуулал хөнгөлөлтүүдийг хамтран хэрэгжүүлэхийн зэрэгцээ Монгол улсын бэлэн бус төлбөр тооцооны хэрэглээг дэмжих үүднээс картыг төлбөрт хүлээн авах сүлжээг өргөтгөж, картаар үйлчлэгч үйлчилгээний байгууллагын тоог 31 хувиар, карт хүлээн авах терминалын тоог 42 хувиар өсгөсөн нь картаар хийсэн худалдан авалтын гүйлгээний дүн өнгөрсөн оны эцсээс даруй 74 хувиар өсчээ.

Түүнчлэн, дэлхий нийтийн хэрэглэгчдийг хил хязгааргүй нэгтгэж байгаа интернэт худалдаа эрхлэх нөхцлийн аюулгүй байдлыг бүрэн хангасан Verified by Visa технологийн үйлчилгээг өргөжүүлэн ажилласнаас гадна шинээр MasterCard-ын Secure Code технологийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг бүрэн хангалаа.

## Гадаад төлбөр тооцоо

Гадаад төлбөр тооцоогоор тэргүүлдэг ХХБ-ны 2008 онд хийгдсэн гадаад гүйлгээний хэмжээ 58 хувиар, гадаадаас хүлээн авсан гүйлгээний хэмжээ 41.9 хувиар тус тус өсч, монгол улсыг дэлхийтэй холбогч санхүүгийн гүүр нь байж чадлаа.

## Moneygram

Олон улсын мөнгөн гуйвуулгын Moneygram байгууллагын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр ХХБ ажилладаг бөгөөд өнгөрөгч онд БНХАУ, БНСУ руу мөнгөн гуйвуулга хийх, мөнгө хүлээн авахад онцгой хөнгөлөлт, урамшуулалттайгаар үйлчилсэн нь харилцагчдын талархлыг ихээр хүлээж, MoneyGram байгууллагаас "2008 оны Маркетингийн шилдэг хамтрагч байгууллага" шагналыг хүртлээ.

## И-биллинг үйлчилгээ

ХХБ цахим нэхэмжлэх буюу И-биллинг үйлчилгээг зах зээлд анхлан нэвтрүүлснээр өдгөө Монгол улсын үүрэн телефоны үйлчилгээ үзүүлэгч бүх операторуудын хэрэглэгчид энэ үйлчилгээнд хамрагдах боломжтой болж, цаг заваа хэмнэж байгаа юм.

## Хувийн банкны үйлчилгээ

Банкны үнэ цэнэтэй, нэр хүнд бүхий томоохон харилцагч иргэд, байгууллагуудад зориулан санхүүгийн мэдээллийн нууцлалыг нь хадгалж, дээд зэргийн тохилог, тав тухтай орчинд хүсэл сонирхол, сэтгэл ханамжид нь нийцүүлэн банкны бүх төрлийн цогц үйлчилгээг өндөр хэмжээнд үзүүлдэг Хувийн банкны төвийн харилцагчдын тоо тайлант онд 30% -иар, татан төвлөрүүлсэн хөрөнгийн хэмжээ 13% буюу 3 тэрбум төгрөгөөр өсч, энэхүү төвийн харилцагч бүрт олгодог санхүүгийн уян хатан нөхцөл, зээлийн хамгийн өндөр хязгаартай банкны шилдэг бүтээгдэхүүн, нэр төрийн баталгаа болсон Платинум карт эзэмшигчийн тоо өмнөх оныхоос 41 %-иар өссөн байна.



## Салбар банкны үйлчилгээ

Тайлант онд ХХБ-ны нийт салбаруудын орлого 20,8 тэрбумд хүрсэн нь өнгөрсөн оныхоос 45,29%-иар өсч, банкны нийт орлогын 23,0%-ийг эзэлж байна.

Салбаруудын зээлийн багцын үлдэгдэл 2008 оны эцэст 85,7 тэрбум төгрөгт хүрсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 40,4%-иар өссөн ба энэ нь тус банкны нийт зээлийн багцын үлдэгдлийн 19,2%-ийг эзэлж, зээлийн хүүгийн орлого 13,8 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны үр дүнгээс 46,3%-иар өссөн үзүүлэлттэй байна.

**Салбаруудын үйлчилгээний орлого**



TDB
TRADE & DEVELOPMENT BANK

# МОНГОЛ УЛС ДАХЬ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИГЧ БАНК

euromoney
conferences

Олон улсын Euromoney байгууллагаас дэлхийн бүс нутгуудад зохион байгуулдаг Хөрөнгө оруулагчдын "Euromoney чуулга уулзалт"-ын ерөнхий ивээн тэтгэгчээр ХХБ 2006 оноос оролцлоо. "Euromoney чуулга уулзалт" Монголд гадаадын хөрөнгө оруулалтыг татах, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх, дотоодын санхүүгийн салбарт олон улсын туршлагыг нэвтрүүлэх зорилгоор 2007 онд Нью Йорк, 2008 онд Лондон хотноо тус тус зохион байгуулагдлаа.

FIFTA
MONGOLIA

ХХБ нь Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлаг (ГХОГХА)-тай 2006 оноос хамтран ажиллаж, хөрөнгө оруулагчдын бизнес форум, хурал зөвлөгөөн, уулзалтуудыг зохион байгуулж, гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжиж, Монголын эдийн засгийн хөгжилд хувь нэмрээ оруулдаг юм.

Tel: (976) 312362, 331133 Fax: (976) 327028, 331155 www.tdbm.mn

# ГАДААД ХАРИЛЦАА ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

## Гадаад харилцаа болон Корреспондент банкны үйл ажиллагаа

ХХБ тайлант онд гадаад харилцаа, хамтын ажиллагаагаа өргөжүүлэх, корреспондент банкуудтай тогтоосон бизнесийн харилцаагаа тогтвортой хадгалах, бусад банк санхүүгийн байгууллагуудтай шинээр харилцаа холбоо тогтоох, олон улсын хөрөнгийн зах зээл дээр эх үүсвэр татах чиглэлээр амжилттай ажиллалаа.

Германы DZ bank, Финляндийн Nordea банкуудтай корреспондент харилцаа тогтоон, Швед кроны гүйвүүлга, төлбөр тооцоог харилцагчдад хүргэх үүднээс Шведийн Nordea банкинд Швед кроны дансыг, төлбөр тооцоог түргэн гүйцэтгэх, банк хоорондын зээлийг дэмжих зорилгоор Russian Agricultural Bank-нд ам.долларын, рублийн дансыг тус тус нээснээр ХХБ-ны ностро данс болон корреспондент банкуудын хүрээ өргөжин тэллээ.



Харилцагчдын гадаад төлбөр тооцоог хурдан шуурхай болгох үүднээс American Express Bank (хуучин нэрээр), Citibank-уудаас харилцагчийн төлбөрийг бүрэн дүнгээр нь хүлээн авагчид шилжүүлэх үйлчилгээг нэвтрүүлсэн нь харилцагчдын эрэлт хэрэгцээнд бүрэн нийцэж чадсан юм.

2008 оны 3 дугаар сард гадаад харилцаа хамтын ажиллагаагаа өргөжүүлэх харилцагчдын төлбөр тооцоог түргэн шуурхай болгох чиглэлээр China Construction банктай "Харилцан ойлголцлын санамж бичиг"-т, мөн оны 12 дугаар сард Agricultural Bank of China-тай " Хил худалдааны төлбөр тооцоог интернет банкаар хийх гэрээ" болон "Алтан түрүү юаны карт нээх гэрээ" зэргийг тус тус байгууллаа.

Түүнчлэн, Монгол улсад гадаадын хөрөнгө оруулагчдыг татах, үр ашгийг дээшлүүлэх, эдийн засгийн өсөлтөд зэрэгцээр нөлөөлж чадахуйц харилцаа, хамтын ажиллагааг бэхжүүлэх чиглэлийг дэмжин ажиллах зорилгоор Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлаг (ГХОГХА)-тай хамтын ажиллагааны гэрээ байгуулж, Английн Лондон хотноо зохиогдсон

Монгол-Европын Хөрөнгө оруулагчдын чуулга уулзалт, Монгол улсад зохион байгуулагдсан "Euromoney-2008" чуулга уулзалт, Монгол Японы бизнес форум зэрэг үйл ажиллагаанд ХХБ нь ерөнхий ивээн тэтгэгч, тэргүүлэгч хандивлагчаар оролцлоо.

## Худалдааны санхүүжилтийн үйл ажиллагаа




Тайлант онд худалдааны санхүүжилтийн зээлийн шугамын ашиглалтыг нэмэгдүүлэн, үр дүнг нь сайжруулан ажилласны зэрэгцээ DZ банк, Agricultural Bank of China банкууд ХХБ-нд зээлийн шугам шинээр баталж, EXIM Bank Republic of China гадаад худалдааны дахин санхүүжилтийн зээлийн шугамыг 4 сая ам.доллар болгон нэмэгдүүлснээр олон улсын нэр хүнд бүхий банк санхүүгийн байгууллагаас ХХБ-нд нээсэн худалдааны санхүүжилтийн зээлийн шугамын нийт хэмжээ оны эцсээр нийтдээ 113 сая ам.долларт хүрч, өмнөх оныхоос 11.9 хувиар нэмэгджээ.




Худалдааны санхүүжилтийн хэмжээ нэмэгдэн, ашиглалт сайжирснаар ХХБ-тай корреспондент харилцаатай ажилладаг дэлхийн нэр хүнд бүхий ING Bank, Mizuho, BhF Bank, UBS, BNP Paribas, Unicredit Bank Moscow, Standard Chartered Bank Plc, IFC, DZ Bank, Commerzbank, Korea EXIM Bank, EXIM Bank Republic of China, Vneshtorgbank Moscow зэрэг банкуудын баталсан зээлийн шугамыг ашиглан баталгаатай аккредитив, баталгаа, урт богино хугацаат худалдааны санхүүжилтийн зээлүүдийг харилцагчдын бизнесийн цар хүрээг өргөжүүлэх, олон улс руу үйл ажиллагаагаа тэлэхэд нь зориулан олгосон нь корреспондент банкуудын харилцаа өндөр хэмжээнд байгааг харуулж буй юм.

## Төслийн зээлжүүлэлтийн үйл ажиллагаа

The World Bank

Дэлхийн банкны "Хувийн хэвшлийг дэмжих 2 үе шаттай төслийн зээл"

JBIC

Японы олон улсын хамтын ажиллагааны банкны "Хувийн хэвшлийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах хоёр үе шаттай төслийн зээл"

Тайлант онд төслийн зээлүүдийн хэрэгжилтийг нэмэгдүүлэхэд гол зорилт тавьж ажилласан бөгөөд Дэлхийн банк, Японы олон улсын хамтын ажиллагааны банк (ЯОУХАБ), KfW банкуудаас тус банкаар дамжуулан олгож буй төрөл бүрийн төслийн зээлийн үйл ажиллагаанд дамжуулан зээлдэгч банкаар ажиллалаа.

Дэлхийн банкнаас хамтран хэрэгжүүлж буй "Хувийн хэвшлийг дэмжих төслийн зээл 2"-ын хүрээнд 2.8 сая ам.доллар болон 850.0 сая төгрөгийн дэд зээлүүд, ЯОУХАБ-наас хэрэгжүүлж буй "Жижиг, дунд

үйлдвэрлэлийг дэмжих байгаль орчныг хамгаалах 2 үе шатлалт төсөл"-д дамжуулан зээлдүүлэгч банкаар сонгогдон, 51.1 мянган ам.доллар болон 530.0 сая төгрөгийн дэд зээлүүдийн эх үүсвэрийн асуудлыг шийдвэрлэн зээлдэгчдэд дамжуулан олголоо.

Түүнчлэн, Германы KfW банкны "Жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих" төслийн зээлийн хүрээнд 323.0 мянган еврогийн дэд зээлийг дамжуулан олгоод байна.

Үүний зэрэгцээ Дэлхийн банкны "Хувийн хэвшлийг дэмжих төслийн зээл 2" төслийн хүрээнд ХХБ-ны "Сургалтын хөтөлбөр-2008"-ыг боловсруулан Дэлхийн банкны техник туслалцааны гэрээний хэрэгжилтийг эхлүүлээд байна.

## Хамтын санхүүжилтийн үйл ажиллагаа

ХХБ нь Монгол улсын эдийн засагт чухал нөлөө үзүүлдэг голлох салбарууд болох нефтийн бүтээгдэхүүний импорт, уул уурхайн салбарын томоохон харилцагчиддаа зориулан олон улсын болон дотоодын банк санхүүгийн байгууллагуудтай хамтран хамтын санхүүжилтийн зээлийг зохион байгуулах ажиллагаагаа жил бүр өргөжүүлсээр ирлээ. Энэ онд гадаадын нэр хүнд бүхий банк санхүүгийн байгууллагуудтай хамтран нийт дүнгээр 19 сая ам.долларын хамтын санхүүжилтийн зээлийг өөрийн томоохон харилцагчиддаа зохион байгуулж хамтран ажиллаа.

Тайлант онд Хамтын санхүүжилтийн зээлээс нийт 1.2 тэрбум төгрөгийн хүүгийн орлого, 11.6 сая төгрөгийн хүүгийн бус орлоготой ажилласан нь мөн онд төлөвлөсөн хэмжээнээс даруй 82 хувиар давуулан биелүүлжээ.

Германы KfW Банкны "Хувийн хэвшлийн жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөрөнгө оруулалтын төслийн зээл"

Korea Eximbank

Солонгосын экспортыг дэмжих зээл

The Export-Import Bank of the Republic of China

Тайваний экспортыг дэмжих банкны санхүүжилтийн зээл



# ХӨРӨНГӨ ЗОХИЦУУЛАЛТ АРИЛЖАА

## Мөнгөний зах зээл

Тайлант онд ХХБ мөнгөний зах зээлд тэргүүлэгч байр суурьтай оролцсон хэвээр байсан төдийгүй бусад арилжааны банкуудтай харилцан ашигтай хамтын ажиллагаа өргөжүүлж, арилжааны банк хоорондын захын үйл ажиллагааг эрчимжүүлэхэд чухал хувь нэмэр оруууллаа.




Мөнгөн хөрөнгийн удирдлагын хүрээнд банкны төлбөрийн чадварыг зохистой түвшинд хангахын зэрэгцээ илүүдэл нөөцийн удирдлагыг сайжруулж, хүүгийн орлогын хэмжээг нэмэгдүүлэх зорилго тавин ажилласан нь үр дүнгээ өгч гадаад, дотоодын санхүүгийн зах зээл эрсдэл өндөртэй байсан өнгөрсөн оныг амжилттай үдлээ.

Оны эцсийн байдлаарх Төв банкны үнэт цаасны багцын хэмжээгээр дотоодын мөнгөний зах зээлийн 31.41%-ийг эзэлж байгаа нь ХХБ-ны хөрвөх чадвар сайн байгааг харуулж байгаа ба бэлэн мөнгөний урсгалыг зохицуулах, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг дэмжин ажиллалаа.

Түүнчлэн, Монголбанкнаас тавьсан төлбөрийн чадварын зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг тухай бүр байнга бүрэн хангаж ажилласан нь харилцагчдын тус банкинд итгэх итгэлийг баталгаажуулах алхам болсны

зэрэгцээ банк хоорондын хадгаламж, зээл, овернайт зээл, үнэт цаасны репо арилжаа зэрэг дотоодын банк хоорондын зах зээлд хэрэглэж болох бүхий л арга хэрэгслүүдийг идэвхитэй ашиглалаа.

### Валютын зах зээл

Монгол улсын банк санхүүгийн салбарт хамгийн олон гадаад валютаар төлбөр тооцоо, гадаад гуйвуулга гүйцэтгэдэг ХХБ олон улсын санхүүгийн зах зээлд өөрийн гэсэн байр суурийг эзлэн, гадаад валютын арилжааны 40 хувийг дангаараа гүйцэтгэж байна.

Өнгөрөгч онд дэлхийн томоохон хөрөнгийн захууд хөдөлгөөнтэй байж, ихээхэн хэмжээний гарз хохирол амссан жил байсан ч ХХБ гадаад, дотоод зах зээлд үйл ажиллагаагаа хэвийн, идэвхитэй үргэлжлүүлэн явууллаа.

Энэ хүрээнд харилцагчидтай харилцах холбоогоо улам бэхжүүлж, шинэ харилцагчдыг татах зорилгоор өрсөлдөгч банкуудаас илүү уян хатан, бага ханшийг санал болгож, зах зээлийн судалгааг тогтмол үр ашигтай гүйцэтгэснээр харилцагчдын тоо өсч, валютын арилжааны эргэлт 137 хувиар нэмэгджээ.

### Алтны арилжаа

Монгол улсын дотоодын арилжааны банкууд дотроос анхлан биет алт худалдан авах албан ёсны зөвшөөрлийг 2000 онд ХХБ авснаас хойш биет алтны арилжааны зах зээл дээр тэргүүлэх байр суурийг эзэлсээр байна.



Тайлант онд Худалдаа, хөгжлийн банк нийт 93 харилцагчтай шууд холбогдож биет алтны арилжаатай холбоотой олон төрлийн үйлчилгээг үзүүлэхийн зэрэгцээ харилцагчиддаа долоо хоног тутам алт, валют, бусад үнэт металлуудын зах зээлийн тойм мэдээллийг хүргэж ажиллалаа.

Тайлант онд Монгол улсын арилжааны банкуудаас анх удаа "Биет алтны своп" арилжааг гадаадын томоохон банкуудын нэг болох "Goldman Sachs international"-тай хамтран амжилттай хэрэгжүүлээд байна.

Хэдийгээр Ашигт малтмалын хуульд заасан зарим нэг заалттай холбоотойгоор биет алтны борлуулалт сүүлийн жилүүдэд буурах хандлага ажиглагдаж байгаа боловч Худалдаа, хөгжлийн банкны зах зээлд эзлэх хувь

хадгалагдсаар байна.

Харилцагчдын өдрөөс өдөрт өсөн нэмэгдэж буй санхүүгийн хэрэгцээнд зориулж олон улсын зах зээлийн ханшийн хүчтэй хөдөлгөөнөөс өөрсдийн хөрөнгөө хамгаалахад нь зориулж мөнгөн хөрөнгийн удирдлагын цогц үйлчилгээнүүдийг сайжруулан хүргэж байна.

### Актив пассивын удирдлага

Тайлант онд банкны актив пассивын удирдлагыг сайжруулж хөрвөх чадвар дээр илүү анхаарч, эрсдэл багатай активт хөрөнгийг байршуулан, үүсэж болох эрсдэлийг боломжит хамгийн бага түвшинд байлгах зорилт тавин, банкны ашигт ажиллагааг нэмэгдүүлж ажиллалаа.

Үүний үр дүнд Монголын арилжааны банкуудаас хамгийн тогтвортой зээлдэгч байж харилцагч аж ахуйн нэгж, байгууллагуудын бизнесийн үйл ажиллагааг дэмжиж, тэдэнд хүргэж буй бүтээгдэхүүн үйлчилгээний хүү, шимтгэлийг хамгийн тогтвортой байлгасан нь банкны ашигт ажиллагаанд үлэмж хувь нэмрийг оруулллаа.

## ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Нийт зээлийн багцын бүтэц




Үйл ажиллагаанаас учирч болох эрсдэлийн удирдлагыг бууруулах цогц арга хэмжээг боловсруулах, хэрэгжүүлэх, хянахад банкны эрсдэлийн удирдлагыг өндөр хэмжээнд байлгах шаардлагын хүрээнд ХХБ тайлант онд эрсдэлийн удирдлагын олон талт шинэлэг аргачлалыг нэвтрүүлэх, зээлийн эрсдэлийн удирдлага, хяналтыг сайжруулах, чанаргүй зээлийн хувь хэмжээг бууруулах, эдийн засгийн төвлөрлийн эрсдэлийг бууруулахад анхааран ажиллалаа.

### Зээлийн эрсдэлийн удирдлага

Салбарын зээлийн эрсдэлийг бууруулах үүднээс салбарын зээлийн зөвлөлийн зээл олгох эрхийн хэмжээг тогтоох загварыг боловсруулж, зээл олгосны дараах хяналтыг сайжруулах, тогтмолжуулах үүднээс салбарын зээлийн багцын чанарыг хагас жил тутамд шалгах үйл явцыг гүйцэтгэлээ. Ингэснээр чанаргүй зээлийн нийт багцад эзлэх хувь хэмжээг 2.0 хувь байснаас 1.5 хувь болгож бууруулж ажиллалаа.

## Зах зээлийн эрсдэлийн удирдлага

Тайлант онд улс орны эдийн засгийн нөхцөл байдлаас учирч болох эрсдэлийг бууруулах үүднээс салбарын санхүүжүүлэлтийн бодлогыг боловсруулан ажилласнаар зээлийн эрсдэлийн удирдлагыг сайжруулж, зээлийн салбарын төвлөрлийн эрсдэлд хяналт тавих үйл ажиллагааг өндөр түвшинд гүйцэтгэх боломжийг нээж өгчээ.

Банкны гадаад валютын болон үнэт цаасны дериватив арилжааны эрсдэлийг хэмжиж, санхүүгийн үндсэн хэрэгслүүдийн ханшийн өөрчлөлтөөс үүдэн банкны багцаас алдаж болох алдагдлыг хянах үүднээс эрсдэлийг үнэлэх олон улсын VAR аргыг ашиглан банкны нээлттэй багцаас алдаж болох алдагдлыг хэмжин удирдлагыг мэдээллээр хангаж ажиллалаа. Банкны багцаас алдаж болох алдагдлыг бодитойгоор үнэлж буй эсэхийг тогтоохдоо буцаан тестлэх (backtesting) аргыг хэрэглэдэг ба VAR ашиг, алдагдлын хэмжээ нь итгэлцлийн түвшинд харгалзан зөвшөөрөх хэмжээнд (BASEL-ийн хорооны шалгуурт) нийцэж байгаад хяналт тавьж ажиллалаа.

Байгууллагын зээлийн чанар




## Хөрвөх чадварын эрсдэлийг удирдах чиглэлээр:

Банкны үйл ажиллагааны хүрээнд хөрвөх чадварын эрсдэлийг бууруулах, сэргийлэх зорилгоор эрсдэлийн удирдлагын цогц бодлогыг боловсруулан ажиллаж, харилцагчийн өмнө хүлээсэн банкны найдвартай ажиллагааг дээшлүүлж, эрсдэлийн удирдлагын үйл ажиллагаанд томоохон ахиц дэвшил гарлаа.

Жижиг, дунд байгууллагын зээлийн чанар




## Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлага

Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагыг сайжруулах, эрсдэлийг бууруулах арга замыг тодорхойлох, хяналтыг тогтмолжуулах үүднээс үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын хороог байгуулсан ба Эрсдэлийн удирдлагын газраас үйл ажиллагааны эрсдэлтэй холбоотой асуудлыг нэгтгэн дүгнэж, тус хороогоор хэлэлцэх ба гарсан шийдвэрийн биелэлтэд хяналт тавьж ажиллаж байна.

Түүнчлэн, жил бүр зээлийн хүүгийн эрсдэлийн хувь хэмжээг харилцагчийн эрсдэлийн үнэлэмж тооцох загварт оруулан шинэчлэн тогтоодог бөгөөд үүний үр дүнд зээлдэгчийн эрсдэлийн үнэлгээнд харгалзах

зээлийн хүү бодитой тогтоогдож, зээлийн багцын эрсдэлийн хувь хэмжээ тогтвортой буурлаа.

# МЭДЭЭЛЛИЙН ТЕХНОЛОГИ

ХХБ мэдээллийн технологийн дэвшилтэд, орчин үеийн үйл ажиллагааг банкны бизнест ашиглан, банкны үйл ажиллагааны тасралтгүй найдвартай байдлыг хангах, дэвшилтэд технологид суурилсан шинэ бүтээгдэхүүн үйлчилгээг судлан нэвтрүүлэх, харилцагчдын өсөн нэмэгдэж буй хэрэгцээ шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн үйлчилгээг мэдээллийн технологийн дэвшлээр бий болгох, банкны үйл ажиллагааг автоматжуулах, ингэснээр ажилтнуудын хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх зэрэгт онцгойлон анхаарч ажилладаг.

Тайлант онд банкны суурь бүртгэлийн системийг шинэчилж, энэхүү системд тулгуурласан олон шинэ модуль, функцийг нэвтрүүлсэн төдийгүй байгууллагын хэрэгцээ шаардлагад хөрөнгийн зохистой удирдлагын систем, худалдааны санхүүжилтийн системийг шинээр нэвтрүүлэх, картын системийг банкны суурь бүртгэлийн системтэй нэгтгэх гэх мэт ажлуудыг эхлүүлээд байна.

Ингэснээр ХХБ харилцагчиддаа найдвартай, чанартай, олон төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээгээр нэгэн зэрэг үйлчлэх боломж нээгдэж, банкны дотоод үйл ажиллагаа хөнгөн шуурхай болж, хувь хүнээс хамаарах эрсдэлийг бууруулах олон давуу талууд бий болох юм.

Харилцагчийн цаг завыг хэмнэсэн интернет банкны дараагийн үе шат гэж болох Мобайл банкны системийг 2008 онд шинээр нэвтрүүлж, зах зээлд гаргахад бэлэн болголоо.

Тайлант онд банкны тоног төхөөрөмжийг шинэчлэх зорилгын хүрээнд орчин үеийн дэвшилтэд технологийн шаардлагад нийцсэн 5 ширхэг ATM, Verifone брэндийн 100 ширхэг GPRS POS терминал, 100 ширхэг Dial up POS терминалыг шинээр нэмж суурилууллаа.

Түүнчлэн, банкны үндсэн системүүдийн сервер компьютер болон өгөгдлийн сангийн серверүүдийг шинэчлэн суурилуулсан нь харилцагчдын мэдээллийн нууцлалыг өндөр түвшинд хамгаалах, банкны систем мэдээллүүдийн найдвартай ажиллагаа, хадгалалт, харилцагчдад үзүүлэх үйлчилгээний цар хүрээг нэмэгдүүлэх, үйлчилгээг түргэн шуурхай хүргэх боломжийг бий болголоо.

# ХҮНИЙ НӨӨЦИЙН УДИРДЛАГА

